

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/89/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Оюундэлгэр

Утас: 99306289

цахим хаяг: a_oyund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.11 № 02/18
танай _____ -ны № _____ -т

АЛТАЙ СУМ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ЦЭЦЭГБАДАМ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЯДБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,130,377	110,301,020
33	АВЛАГА	4,076,176	16,404,350
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00	3,404,350
335	Бусад авлага	3,898,950	13,000,000
3351	Байгууллагаас авах авлага	3,898,950	13,000,000
35	БАРАА МАТЕРИАЛ	83,054,201	93,896,670
351	Түүхий эд материал	3,300,000	1,040,000
35130	Эм боох материал	3,300,000	1,040,000
354	Хангамжийн материал	78,814,201	91,916,670
35410	Бичиг хэргийн материал	5,407,738	4,179,540
35420	Аж ахуйн материал	45,600,663	54,745,950
35450	Барилгын засварын материал	3,130,500	3,810,000
35460	Хүнсний материал	4,680,500	9,164,880
35470	Бусад хангамжийн материал	19,994,800	20,016,300
35600	Мал амьтал	940,000	940,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,416,427,376	5,368,993,376
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,416,427,376	5,368,993,376
392	Биет хөрөнгө	5,396,427,376	5,348,993,376
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,997,863,489	4,997,863,489
39202	Хуримтлагдсан элэгдэл	-85,218,510	-172,704,245
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000	23,500,000
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,500,000	-23,500,000
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	196,223,357	207,377,257
39206	Хуримтлагдсан элэгдэл	-165,169,198	-175,147,987
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	218,161,372	271,417,272
39208	Хуримтлагдсан элэгдэл	-133,851,887	-143,198,469
39214	Бусад үндсэн хөрөнгө	330,226,768	330,226,768
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,327,612	-8,870,307
39217	Ном	40,519,599	42,029,599
393	Биет бус хөрөнгө	20,000,000	20,000,000
39301	Програм хангамж	1,004,000	1,004,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,004,000	-1,004,000
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000	20,000,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,503,557,753	5,479,294,396
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,503,557,753	5,479,294,396
51	Засгийн газрын хувь оролцоо	5,503,557,753	5,479,294,396
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,910,020,624	1,910,020,624
51101	Өмч: - төрийн	1,910,020,624	1,910,020,624
512	Хуримтлагдсан үр дүн	2,570,306,362	2,564,043,005
51210	Өмнөх үеийн үр дүн	2,570,306,362	2,564,052,115
51220	Тайлант үеийн үр дүн	00	-18,009,110
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,023,230,767	1,023,230,767
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,503,557,753	5,479,294,396

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	4,202,190,149	1,216,271,038
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,061,943,849	94,279,900
120	Нийтлэг татварын бус орлого	3,056,283,849	94,279,900
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,056,283,849	94,279,900
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00	2,400,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000	8,912,700
1200045	Үнэ толбөргүй хүлээн авсан орлого	3,053,883,849	82,967,200
122	Тусламжийн орлого	5,660,000	00
122001	Хандив тусламж /дотоод/	5,660,000	00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,572,500	161,194,238
131007	Тусгай зориулалтын шилжүүлээс санхүүжих	997,673,800	960,796,900
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,419,100	30,937,857
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000	30,937,857
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,919,100	00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,153,400	130,153,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,153,400	130,153,400
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00	102,981
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00	102,981
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,202,175,517	1,234,280,148
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,202,175,517	1,234,280,148
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,089,251,833	1,183,493,721
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744,804,365	762,454,026
210101	Үндсэн цалин	512,332,523	542,769,450
210102	Нэмэгдэл	169,475,216	174,162,098
210104	Урамшуулал	62,996,626	45,522,478
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,853,615	102,907,400
210201	Тэтгэврийн даатгал	63,956,600	72,416,600
210202	Тэтгэмжийн даатгал	7,503,830	7,622,600
210203	ҮОМНӨ-ний даатгал	6,003,443	6,098,100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,489,569	1,524,500
210205	Эрүүл мэндийн даатгал	14,900,173	15,245,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,017,300	123,735,991
210301	Гэрэл, цахилгаан	4,408,016	4,913,491
210302	Түлш, халаалт	115,309,284	106,073,600
210303	Цэвэр, бохир ус	12,300,000	12,748,900
2104	Хангамж, бараа материалын зардал	17,141,980	13,998,986
210401	Бичиг хэрэг	1,704,970	1,130,100
210402	Тээвэр, шатахуун	2,463,730	3,529,465
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	675,000	525,000
210404	Ном, хэвлэл	3,864,580	3,701,225
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	212,400	00
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх, ахуйн эд хүйс	00	00
2105	Өрөөлөгч зардал	00	00
2106	Энгийн үйлчилгээний зардал	00	00
2107	Хувийн зардал	00	00
2108	Өрөөлөгч зардал, өрөөлөгч зардал	00	00

2106	Эл хогшил, урсгал засварын зардал	858,500	6,247,870
210604	Урсгал засвар	858,500	6,247,870
2107	Томилгог, зочны зардал	00	255,400
210702	Дотоод албан томилгог	00	255,400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000	2,118,500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	1,398,500
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	720,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,248,153	127,959,648
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,052,500	5,464,150
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,940,000	6,635,198
210903	Үндсэн хөрөнгийн эзгдэл, хоргодол	60,255,653	115,860,300
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,923,684	50,786,427
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,277,200	46,836,537
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00	102,981
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,277,200	28,455,000
213208	Холоо орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00	18,278,556
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,255,884	668,581
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,255,884	668,581
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	390,600	3,281,309
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	390,600	3,281,309
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,000,014,632	-18,009,110
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,000,014,632.38	18,009,110.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,890,020,624	5,612,521	-384,935,578	1,510,697,567
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,890,020,624	5,612,521	-384,935,578	1,510,697,567
C07	Тайлант үеийн үр дүн	00	00	-7,829,001	-7,829,001
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624	1,023,230,767	2,570,306,362	5,503,557,753
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624	1,023,230,767	2,570,306,362	5,503,557,753
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00	00	-6,254,247	-6,254,247
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,910,020,624	1,023,230,767	2,564,052,115	5,497,303,506
D08	Тайлант үеийн үр дүн	00	00	-18,009,110	-18,009,110
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624	1,023,230,767	2,546,043,005	5,479,294,396

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,142,646,300	1,133,303,838
120	Нийтлэг татварын бус орлого	2,400,000	11,312,700
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,400,000	11,312,700
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00	2,400,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,400,000	8,912,700
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,140,246,300	1,121,991,138
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	997,673,800	960,796,900
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,419,100	30,937,857
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	500,000	30,937,857
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	6,919,100	00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,153,400	130,153,400
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	135,153,400	130,153,400
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00	102,981
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00	102,981
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,646,300	1,133,303,838
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,142,646,300	1,133,303,838
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,028,258,616	1,079,113,061
210101	Үндсэн цалин	744,981,591	762,276,800
210102	Нэмэгдэл	512,509,749	542,592,224
210104	Урамшуулал	169,475,216	174,162,098
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,996,626	45,522,478
210201	Тэтгэврийн даатгал	93,853,615	102,907,400
210202	Тэтгэмжийн даатгал	63,956,600	72,416,600
210203	ҮОМЦО-ний даатгал	7,503,830	7,622,600
210204	Ажилгүйдлийн даатгал	6,003,443	6,098,100
210205	Эрүүл мэндийн даатгал	1,489,569	1,524,500
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,900,173	15,245,600
210301	Гэрэл, цахилгаан	132,017,300	123,735,991
210302	Түлш, халаалт	4,408,016	4,913,491
210303	Цэвэр, бохир ус	115,309,284	106,073,600
2104	Хангамж, бараа материалын зардал	12,300,000	12,748,900
		9,281,080	11,579,224

210401	Бичиг хэрэг	522,500	965,867
210402	Тээвэр, шатахуун	2,476,400	2,562,465
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	625,000	525,000
210404	Ном, хэвлэл	4,194,580	3,990,458
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	212,400	1,259,434
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250,200	2,276,000
2105	Нормативт зардал	34,169,900	40,985,496
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,812,100	625,600
210502	Хоол, хүнс	23,400,300	38,591,530
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,957,500	1,768,366
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,745,500	4,600,100
210604	Урсгал засвар	2,745,500	4,600,100
2107	Томилолт, зочны зардал	00	255,400
210702	Дотоод албан томилолт	00	255,400
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000	8,720,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	8,000,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	720,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,817,630	24,052,650
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,790,000	18,795,050
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,027,630	5,257,600
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,387,684	54,190,777
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,277,200	46,836,537
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00	102,981
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,277,200	28,455,000
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00	18,278,556
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,719,884	4,072,931
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,719,884	4,072,931
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	390,600	3,281,309
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	390,600	3,281,309
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00	00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00	00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00	00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00	00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,093,350,300	1,089,400,4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,350,300	1,089,400,4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,064,860,700	1,060,945,4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762,276,800	762,276,80
210101	Үндсэн цалин	526,680,300	542,592,22
210102	Нэмэгдэл	191,115,300	174,162,09
210104	Урамшуулал	44,481,200	45,522,47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,907,400	102,907,40
210201	Тэтгэврийн даатгал	72,416,600	72,416,60
210202	Тэтгэмжийн даатгал	7,622,600	7,622,60
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,098,100	6,098,10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,500	1,524,50
210205	Эрүүл мэндийн даатгал	15,245,600	15,245,60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,017,300	123,735,99
210301	Гэрэл, цахилгаан	8,194,800	4,913,49
210302	Түлш, халаалт	106,073,600	106,073,60
210303	Цэвэр, бохир ус	12,748,900	12,748,90
2104	Хангамж, бараа материалын зардал	6,725,900	6,447,82
210401	Бичиг хэрэг	539,300	539,30
210402	Тээвэр, шатахуун	2,638,600	2,562,46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	662,500	525,00
210404	Ном, хэвлэл	348,600	344,35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	259,700	200,70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,277,200	2,276,00
2105	Нормативт зардал	41,101,400	40,985,49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	662,300	625,60
210502	Хоол, хүнс	38,603,400	38,591,53
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,835,700	1,768,36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,136,100	3,136,10
210604	Урсгал засвар	3,136,100	3,136,10
2107	Томилолт, зочны зардал	318,200	255,40
210702	Дотоод албан томилолт	318,200	255,40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000	720,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000	720,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,657,600	20,480,40

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,400,000	15,222,8
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	5,257,600	5,257,6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,489,600	28,455,0
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,489,600	28,455,0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,489,600	28,455,0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,093,350,300	1,093,350,3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	960,796,900	960,796,9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	960,796,900	960,796,9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	130,153,400	130,153,4
132001	Орон нутгийн төсвөөс	130,153,400	130,153,4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,400,000	2,400,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000	2,400,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64	6
620001	Удирдах ажилтан	01	0
620002	Гүйцэтгэх ажилтан	41	4
620003	Үйлчлэх ажилтан	22	2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алтай сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуультай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Оюундэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 25-нээс 2021 оны 01 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын хүүхдийн сургууль нь сумын сургуулийн насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулж сургуултын чанарыг сайжруулах, суралцагчийн бие бялдар авъяас чадварыг хөгжүүлэх үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах, Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол, шийдвэр, аймаг суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгон ажиллаж байгаа ерөнхий боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тус байгууллага нь 2021 онд "Хүн бүр хариуцлага хандлага төлөвшлөө сайжруулан, багш хичээлийн бэлтгэлээ чанартай хангаж, сурагчид гэрийн даалгавраа тогтмол хийж, эх хэлний чадвараа дээшлүүлж, сэтгэн бодох хурдаа ахиулан, элсэлтийн ерөнхий шалгалтандаа амжилт гаргах" зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 тоот тогтоолоор "Үдийн хоолны норматив тогтоох тухай"

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2019 оноос шинэчлэгджээ.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор УЕПГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт орлого 1216.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 24.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.3 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлагын оны эхний үлдэгдэл 4.1 сая төгрөгийн үлдэгдэл байсан нь тайлант онд бүрэн барагдаж, шинээр 16.4 сая төгрөгийн авлага үүссэн байна. 2021 оны 12 дугаар сарын 23-нд аймгийн Засаг даргын А/840 тоот захирамж гарч Санко Маркет Монголия ХХК-аас Ухаалаг самбар авах гэрээ хийгдэж, 13.0 сая төгрөгний байгууллагаас авах авлага нэмэгдсэн байна. Мөн нэмэлт санхүүжилтийн үлдэгдэлээс татан төвлөрүүлсэн 3.4 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 83.1 сая төгрөгөөс 93.9 сая төгрөг болж 10.8 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 62.1 сая төгрөг, хандиваар 20.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 65.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 5416.4 сая төгрөг, оны эцэст 5369.0 сая төгрөг болж 47.4 сая төгрөгөөр буурсан байна. Хандиваар 62.7 сая төгрөг, төслийн санхүүжилтээр 5.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардал 115.9 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 68.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 2.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 5503.6 сая төгрөг байсан оны эцэст 5479.3 сая төгрөг болж тайлант онд 24.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт 6.2 сая төгрөгийн бичилт хийсэн. ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2546.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Алтай сумын сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1216.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1216.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1042.2 сая төгрөгөөр батлан ирүүлж, тайлант хугацаанд төсвийн тодотгол нэг удаа хийгдэж 1093.4 сая төгрөг болж 51.2 сая төгрөгөөр өссөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1093.4 сая төгрөгийн төсөв баталснаас 960.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 130.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 960.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 130.2 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 2.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1089.4 сая төгрөгийг зарцуулж 3.9 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1089.4 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 3.3 сая төгрөгөөр, хангамж материалын

зардлыг 0.3 сая төгрөгөөр, нормативт зардлыг 0.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1.5 сая төгрөгийн татан төвлөрүүлтийн буцаалт, дээд шатны төсвийн захирагчаас 29.5 сая төгрөг, түрээсийн сурах бичгийн үнэ 3.6 сая төгрөг, түрээсийн орлого 5.3 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас 0.1 сая төгрөгийн орлого тус тус орж нийт 39.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт орсон байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас түрээсийн сурах бичгийн үнэ 3.6 сая төгрөг, урсгал засварын зардалд 1.5 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш нарын тэтгэмжид 18.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 8.0 сая төгрөг, хог хаягдал зайлуулж хортон шавь устгах зардалд 1.1 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.6 сая төгрөг, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжид 0.1 сая төгрөг тус тус зарцуулж 3.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 148 мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээллэж 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар заалны түрээсийн орлогыг төрийн сангийн харилцах дансаар дамжуулаагүй, эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч үр дүнг тооцож бүртгэлд тусгаагүй зарим эд хөрөнгийг багцалсан бөөн дүнгээр бүртгэсэн гэсэн 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байна. Аймгийн Засаг дарга 2021.12.15-нд А/778 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар боловсролын байгууллагуудад төсвийн зохицуултыг 649.7 сая төгрөгөөр, 2021 оны 12.23-нд А/842 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар боловсролын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг 16.9 сая төгрөгөөр, 2021.12.23-ны А/842 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар Боловсролын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг 275.3 сая төгрөгөөр нийт 941.9 сая төгрөгийн зохицуулалт хийжээ. Үүнээс 13 сургууль ухаалаг самбар авна гээд үдийн хоолны зардлаас 195.0 сая төгрөгийг зохицуулалт хийж, Санко маркетинг монголия ХХК гэрээ хийж одоо хүртэл самбар нь ирээгүй дээрхи байгууллагууд 195.0 сая төгрөгөөр авлагаа нэмэгдүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар бараа материалын 6.4 сая төгрөгний И баримт аваагүй гүйлгээ хийсэн, НДШ тооцоо хийхэд байгууллагаас төлөх дүнгээс 3.3 сая төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн тооцсон, Захирлын тушаалаар 1.03 сая төгрөгийг ахмадууд болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хүндэтгэл, хоол хүнс олгосон, Шилэн дансны 3 мэдээлэл хугацаа хоцроосон зөрчил илэрлээ.

Аудитаар нийт 10.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: НДШ тооцоо хийхэд байгууллагаас төлөх дүнгээс 3.3 сая төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн тооцсон

4.1 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг мөрдөн ажиллах.

4.2 Илрүүлэлт: Захирлын тушаалаар 1.0 сая төгрөгийг ахмадууд болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хүндэтгэл, хоол хүнс олгосон

4.2 Өгсөн зөвлөмж: " Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 дахь урамшуулал олгохгүй байх " заалтыг мөрдөн ажиллах.

4.4.2 И баримттай холбоотой асуудал

4.3 Илрүүлэлт: Аудитаар бараа материалын 6.4 сая төгрөгний И баримт аваагүй гүйлгээ хийсэн.

4.3 Өгсөн зөвлөмж: "Татварын ерөнхий хуулийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" заалтыг мөрдөн И баримтаар гүйлгээ хийдэг байх

4.4.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.4 Илрүүлэлт: Шилэн дансны 3 мэдээлэл хугацаа хоцроосон зөрчил илэрлээ.

4.4 Өгсөн зөвлөмж: " Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын сургууль	4	10.7	0	0.0	0	0.0	0	0	4	10.7

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

А.ОЮУНДЭЛГЭР